



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар A/18

Ховд

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.17.1, 19.20.2, 19.21 дэх заалтууд, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Хүүхдийн оношилгоо эмчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх “Янзага” үүдэн эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 1 жилээр, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх “Эммед партнер 1” эмнэлэг, эд эс судлалын шинжилгээ оношилгоо, зөвлөгөө үзүүлэх “Ач оюун далай” эмнэлгүүдийн үйл ажиллагааг тус бүр 3 жилээр, 1 дүгээр зэрэглэлийн эмийн сангийн үйлчилгээ үзүүлэх “Монос Ховд”, 2 дугаар зэрэглэлийн эмийн сангийн үйлчилгээ үзүүлэх “Вансэмбэрүү 2” эмийн сангуудын мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 6 сараар тус тус сунгасугай.

2. Өөрийн үйл ажиллагааны чиглэлээр сүүлийн зургаан сарын дотор тогтмол үйл ажиллагаа явуулаагүй, өмнөх хуралдааны заавар, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй эмэгтэйчүүдийн оношилгоо эмчилгээний “Ач үр”, өөрийн гэсэн ажлын байргүй тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй, тайлан мэдээгээ ирүүлдэггүй тархины цахилгаан бичлэгийн оношилгоо үзүүлэх “Биндэрьяа”, бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, ажлын байргүйгээс ажлын байрны дүгнэлт гаргуулаагүй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй дотрын өвчний оношилгоо эмчилгээ үзүүлэх “Мандах эмч”, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй “Хаш гэрэлт”, захирал нь хот шилжиж үйл ажиллагаа нь

Zax A/18 Ch


02 00033

зогссон “Сэтэр хүрэн” шүдний эмнэлэг, ажлын байрны дүгнэлт гаргуулаагүй тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх “Эммед партнер 2”, “Скай мед вестерн” эмнэлгүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус цуцалж, төвлөрсөн усан хангамжийн системд холбогдоогүй, халдвар хамгааллын дэглэм хангалтгүй, хүний нөөцийг стандартын дагуу ажиллуулаагүй “Энхрий жаргалан” шүдний эмнэлгийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг 3 сараар түр түтгэлзүүлсүгэй.

3. Өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлж стандартын шинэ байранд үйл ажиллагаагаа эрхлэх болсон “Булган эмийн эргэлтийн сан”, үйл ажиллагааны байршлаа өөрчилсөн “Монос Ховд эмийн сан, “Энхрий жаргалан” шүдний эмнэлгүүдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын байрны өөрчлөлт хийсүгэй.

4. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан, түтгэлзүүлсэн, цуцалсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, оношлогоо эмчилгээний тусламж үйлчилгээний шинэ төрөл техник, технологи, бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжиж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Ц.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

з  
гү

Там